



ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 580

Улаанбаатар хот
Утас: (976-11) 322 702

Түр журам батлах тухай

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн дүрмийн 15.3.3 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. ХИС-ийн Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө зохиох, хичээл сонголтын үйл ажиллагааг зохицуулах түр журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг оюутнуудад шуурхай мэдэгдэж хэрэгжилтийг хангах арга хэмжээ авахыг Сургалт, судалгааны хөгжил, аудит үйлчилгээний алба /Б.Хишигтогтох/, Мэдээлэл технологийн алба /С.Диваасамбуу/, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд /А.Амаржаргал, Г.Амарбаясгалан, Т.Алтанцэцэг, Д.Уламбаяр/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.ЧУЛУУНДОРЖ

01544



Захирлын 2016 оны 12-р сарын 16-ны өдрийн
580-тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ХИС-ийн Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө зохиох, хичээл сонголтын үйл ажиллагааг зохицуулах түр журам

Журмын үндэслэл. ХИС-ийн Захиргааны зөвлөлийн 2016 оны 9-р сарын 19-ний өдрийн хурлын шийдвэр, 2016-2017 оны хичээлийн жилд “Сонгох сургалтанд шилжих үйл явцыг эрчимжүүлэх, шаардлагатай эрх зүйн орчин, нөхцлийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд энэхүү түр журмыг боловсруулсан.

Журмын зорилго. Энэхүү журмаар “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө”, цаашид суралцах улирлуудадхийгдэх “Хичээл сонголт”, хос болон давхар мэргэжил эзэмших, бакалавр, магистр, докторын түвшингийн сургалтын үйл ажиллагаануудыг зохицуулахад оршино.

1. ХИС-ийн оюутан, магистрант, докторант (цаашид оюутан) өдөр, орой, эчнээ, экстерант хэлбэрийн сургалтад хамрагдах оюутан өөрийн суралцах хичээлийн жил, улирлуудад судлах хөтөлбөрийн жагсаалтыг зөвлөх багшийн удирдлага дор урьдчилан нарийвчлан тооцож гаргахыг **“Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө”** гэнэ. Энэхүү төлөвлөгөө нь тухайн оюутан цаашид суралцах хугацааны турш сургалтын төлөвлөлтийг харуулсан үндсэн баримт бичиг болно.
2. Оюутны ганцаарчилсан төлөвлөгөөнөөс тухайн улиралд орох боломжтой хөтөлбөрүүдийг системд боловсруулж, тухайн улирлын хичээлийн нэгдсэн хуваарийн дагуу хичээллэх гариг, өрөө, бүлэг, багшийг сонгож, оюутан өөрийн хичээлийн хуваарь үүсгэхийг **хичээл сонголт** гэнэ.
3. Бүх түвшингийн сургалтад шинээр элсэгч болон шилжин суралцагчид “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө”-г **намрын улиралд** 8-р сарын 15-30-ны өдрүүдэд, **хаврын улиралд** намрын улирлын хичээл дууссанаас хойш 2 долоо хоногт багтаан хийж, зөвлөх багшаар баталгаажуулж, түүнийгээ хэвлэж, өөрийн харьяалагдах сургалтын албаны менежерт цаасан хэлбэрээр хураалгаж, архивт хадгалуулна.
4. Идэвхитэй суралцаж буй оюутан “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө”-нд хөдөлгөөн оруулах тохиолдолд хаврын ба намрын улирлын хичээл дууссанаас хойш 2 долоо хоногт багтаан шинэчилж, зөвлөх багшаар баталгаажуулж, түүнийгээ хэвлэж, өөрийн харьяалагдах сургалтын албаны менежерт цаасан хэлбэрээр хураалгаж, архивт хадгалуулна.
5. Оюутан өөрийн суралцах “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө” -гөө өөрчлөх, засвар оруулах тохиолдолд харьяалагдах тэнхимд бичгээр хүсэлт гаргана. Тухайн тэнхим хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж өгнө.
6. Тэнхим тухайн оюутны ганцаарчилсан төлөвлөгөөний хөдөлгөөнийг зөвшөөрсөн тохиолдолд харьяалагдах сургалтын албанд мэдэгдэж, тухайн оюутны ганцаарчилсан төлөвлөгөөнд дээр засвар хийх эрхийг авна. Сургалтын алба оюутны ганцаарчилсан төлөвлөгөөнд засвар хийх эрхийг ажлын 2 хоногийн хугацаатай нээнэ.
7. “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө” боловсруулахад дараалал.
 - a. Оюутны вэб дахь өөрийн суралцаж буй “Сургалтын төлөвлөгөө” -тэй сайтар танилцаж, цаашид хэрхэн суралцах жил улирлаа тооцож, хувийн суралцах төлөвлөгөөний төслөө гаргана.
 - b. Өөрийн гаргасан төлөвлөгөөний төслийн дагуу “Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө”-г зохиох талаар зөвлөх багштайгаа уулзаж, нийт суралцсан улирлуудын дүн болон цаашид суралцах хичээлийн жил, улирлуудыг тооцож, ганцаарчилсан төлөвлөгөөг үүсгэнэ.

- с. Тухайн оюутны ганцаарчилсан төлөвлөгөөг зөвлөх багш сайтар хянаж, дахин боловсруулж сургалтын албаны системд баталгаажуулна. Баталгаажуулсан ганцаарчилсан төлөвлөгөөгөө зөвлөх багш эсвэл оюутан нэг хувь хэвлэж, оюутан болон багш гарын үсгээ зурж, сургалтын албаны менежерт оюутнаар хүргүүлнэ.
 - д. Оюутан баталгаажуулсан "Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө"-ний цаасан хувилбарыг харьяалагдах сургалтын менежерт хүлээлгэн өгч гарын үсэг зурснаар уг төлөвлөгөө албан ёсны болно.
 - е. Сургалтын албаны менежер оюутан бүрийн баталгаажуулсан "Оюутны ганцаарчилсан төлөвлөгөө"-г хүлээн авч оюутны хувийн хэрэгт хийж архив үүсгэнэ.
8. Оюутан бүр өөрийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг зохиож, холбогдох албан тушаалтнаар батлуулж, системд бүртгэгдсэн байх ёстой. Хэрэв системд бүртгэгдээгүй тохиолдолд цаашид суралцах болон сонголт хийх эрх үүсэхгүй.
9. Оюутны хичээл сонголт нь энэ журмын дагуу баталгаажсан ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу явагдах ба ХИС-ийн **"Сургалтын төлбөрийн тооцоо хийх журам"**-ын дагуу тухайн улиралд судлах нийт кредитийн төлбөрийг сургуулийн дансанд байршуулж, санхүүгийн албаны ажилтан баталгаажуулснаар тухайн оюутан хичээл сонголт хийх эрхтэй болно.
10. **Хичээл сонголт** хийх эрх сургалтын албаны системд тухайн улирлын хичээл эхлэх өдрөөс 2 долоо хоногийн өмнө нээгдэнэ. Тухайн улирлын хичээл эхлэх, дуусах хугацааг хичээлийн жилийн **"Сургалтын нэгдсэн хуанли"** -аас харах боломжтой.
11. Зөвлөх багш өөрийн хариуцаж буй оюутнуудын ганцаарчилсан төлөвлөгөөн дэх тухайн улирлын хичээлүүдийг сонгоход зөвлөгөө өгч, хичээл сонголтыг хянаж, сонголт бүрэн хийгдсэн тохиолдолд системд баталгаажуулна.
12. Зөвлөх багш системд баталгаажуулсан тохиолдолд оюутан тухайн улирлын хичээл сонголтод хөдөлгөөн хийх эрхгүй болно.